

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ.....	4
БҮЛЭГ 1. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,067.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт хуваарилах орлогын шилжүүлгийг 6,853.2 сая төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.....	6
1.1 Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас аймгийн төсвийн орлогыг анх баталсан дүнгээс 17,632.9 сая төгрөгөөр бууруулан 63,060.5 сая төгрөгөөр өөрчлөн баталсан байна.....	6
1.2 Орон нутгийн төсвийн орлогын хүрээнд газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйгээс 2,539.2 сая төгрөгийн орлого тасарсан нь төлөвлөсөн орлогын гүйцэтгэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэн байна.....	7
БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээнд тайлант хугацааны дундуур өөрчлөлт оруулсан нь төслийн хэрэгжилтийн төлөвлөлт, хэрэгжилтийн дараалалд нөлөөлж, иргэдийн оролцоо, итгэлцлийг бууруулах, мөн тухайн жилийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэсэн байна.....	10
2.1 Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 13,067.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 6,853.2 сая, нийт 19,920.5 сая төгрөгийг бууруулж баталсан байна.....	10
2.2 Орон нутгийн төсвийн зарлагын бүтцэд урсгал зардал 64.3 хувь, хөрөнгийн зардал 34.9 хувь, цэвэр зээл 0.9 хувийг тус тус эзэлж байгаа нь төсвийн ихэнх хэсэг нь урсгал зардалд чиглэж, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын чиглэлийн санхүүжилт харьцангуй бага байгааг илтгэж байна.....	11
БҮЛЭГ 3. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 376 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 56.7 хувьтай байгаа нь төсвийн хүндрэлээс гадна зураг төсөв, худалдан авах ажиллагаа, байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байсантай холбоотой бөгөөд хөрөнгө оруулалтын төсөв бүрэн ашиглагдахгүй үлдэх, иргэдийн эрэмбэлсэн ажлууд хойшлох, төрийн үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмж саарах сөрөг үр дагавар үүсгэж байна.....	13
3.1 Тайлант онд 350 төсөл, арга хэмжээг 38,599.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталсан бөгөөд гүйцэтгэл 55.5 хувь буюу гүйцэтгэл 21.427.5 сая төгрөг байна.....	13
3.2 Их засварын чиглэлээр хэрэгжүүлэх нийт 10 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн боловч Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласнаас шалтгаалан санхүүжилтийг дутуу олгосон байна.....	14
3.3 Орон нутгийн хөрөнгө оруулалт 75.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.....	15
3.4 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 84.3 хувийн гүйцэтгэлтэй байна.....	16
БҮЛЭГ 4. Орон нутгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүдийг төсвийн төсөлтэй уялдуулан тайлагнаж, тайланг ИТХ-аар “Хангалттай” гэж үнэлсэн боловч зарим арга хэмжээний хэрэгжилт харилцан адилгүй байгаа нь төсөв, үр дүнгийн хамаарлыг илүү бодитой үнэлэх, хэрэгжилтийн тайлагналыг чанаржуулах шаардлагатайг харуулж байна.....	17
4.1 Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн тайлагнасан байна.....	17
4.2 Сүхбаатар аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний тайланг Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2025 оны 46 дугаар тогтоолоор нийт төлөөлөгчдийн 96.2 хувийн саналаар “Хангалттай” гэж үнэлжээ.....	18
БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, зарцуулсан боловч нэмэлт орлогын бүтэц, зориулалт, үлдэгдлийн удирдлагад хяналтыг тогтмол хэрэгжүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого, хандив, дээд шатны шилжүүлгийн бүртгэл, тайлагналыг илүү нэгдсэн байдлаар сайжруулах шаардлагатай байна.....	19
БҮЛЭГ 6. Шилэн данс, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий судалгаа.....	19
6.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:.....	20
6.3 Ерөнхий чиглэлийн судалгааны талаар:.....	20
ДҮГНЭЛТ.....	22
ЗӨВЛӨМЖ.....	23
6.4 Холбогдох байгууллагын санал.....	24
6.5 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:.....	25
6.7 Аудитын тайлан баталгаажуулсан тушаал.....	26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
АТҮТ	Автотээврийн үндэсний төв
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХДАА	Санхүү аудит дотоод аудитын алба
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ҮТП	Үйлдвэр технологийн парк
ХЖТ	Хөгжимт жүжгийн театр
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХШҮ	Хяналт шинжилгээ үнэлгээ
ШДТХ	Шилэн дансны тухай хууль

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Төсвийн орлого
Хүснэгт №2	Улсын төсвөөс хуваарилах орлого
Хүснэгт №3	Аймгийн ИТХ-аар баталсан 2025 оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэр
Хүснэгт №4	Төсвийн орлогын гүйцэтгэл
Хүснэгт № 5	Татварын орлогын гүйцэтгэл
Хүснэгт № 6	Татварын бус орлогын гүйцэтгэл
Хүснэгт № 7	Төсвийн зарлагын гүйцэтгэл
Хүснэгт № 8	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт № 9	Их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
Хүснэгт № 10	Удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаар гүйцэтгэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт № 11	Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт № 12	Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/
Хүснэгт № 13	Хөгжлийн төлөвлөгөөний биелэлт
Хүснэгт № 14	Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэл
Хүснэгт № 15	Хэвлэл мэдээллийн байгууллагатай хийсэн гэрээ

Аудит үндэслэл, эрх	хийх бүрэн	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/179 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын сэдэв, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.</p>
Аудитын зорилт		<p>Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахад дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон нутгийн 2025 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх 2. Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх 3. Тухайн жилд хэрэгжих хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл 4. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх 5. Нэмэлт төсвийн гүйцэтгэл 6. Шилэн дансны тухай, ТХТ хуулийн хэрэгжилт
Аудитын хүрээ	хамарсан	<p>Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Сүхбаатар аймгийн 2025 оны төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт		<p>Аудитыг гүйцэтгэхдээ АДБООС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа		<p>Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Мөнхбамбар, О.Барчидгүнсэн нар гүйцэтгэв.</p>

БҮЛЭГ 1. Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,067.3 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт хуваарилах орлогын шилжүүлгийг 6,853.2 сая төгрөгөөр тус тус бууруулан баталжээ.

1.1 Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас аймгийн төсвийн орлогыг анх баталсан дүнгээс 17,632.9 сая төгрөгөөр бууруулан 63,060.5 сая төгрөгөөр өөрчлөн баталсан байна.

1.1.1 Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 10 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлогыг нийт 80,693.4 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан.

Хүснэгт №1 Төсвийн орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Дүн (сая төгрөг)	Дүнд эзлэх хувь
Татварын орлого болон татварын бус орлого	27,410.0	34.0
Сум төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	1,891.5	2.3
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	22,417.2	27.8
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлого	26,562.7	32.9
Төсвийн байгууллагын өөрийн орлого	65.0	0.1
Урьд оны төсвийн үлдэгдэл	2,347.0	2.9
Нийт	80,693.4	100%

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ИТХ-ын төсөв батлах, тодотгох тухай тогтоол

1.1.2 Сүхбаатар аймгийн 2025 оны орон нутгийн төсвийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, аймгийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2-т заасан цаглабарын дагуу тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

1.1.3 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Сүхбаатар аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 22,417.2 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 26,562.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

1.1.4 Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр өөрчлөлт оруулж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,067.3 сая төгрөг буюу 58.3 хувиар бууруулан 9,349.9 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт хуваарилах орлогын шилжүүлгийг 6,853.2 сая төгрөг буюу 25.8 хувиар бууруулан 19,709.5 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Хүснэгт №2 Улсын төсвөөс хуваарилах орлого /сая.төг/

Улсын төсвөөс хуваарилах орлого	Анх баталсан 2024.12.12	Тодотгол 2025.07.09	Өсөлт /бууралт	Хувь
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	22,417.20	9,349.90	-13,067.30	58.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлого	26,562.70	19,709.50	-6,853.20	25.8
НИЙТ	48,979.90	29,059.40	-19,920.50	40.7

1.1.5 Тайлант онд аймгийн 2025 оны төсөвт 3 удаа, сумд 1 удаа өөрчлөлт оруулж тодотгол хийжээ. Үүнээс аймгийн ИТХ-аар баталсан тодотголыг авч үзвэл:

Хүснэгт №3 Аймгийн ИТХ-аар баталсан 2025 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /сая.төг/

№	Орлогын нэр, төрөл	Анх баталсан 2024.12.20 №10	Тодотгол 2025.07.29 №32	Өссөн /буурсан/	Өсөлт, /бууралт/ хувь
1	Татварын орлого	20,121.40	20,121.40	-	-
2	Татварын бус орлого	7,288.60	7,448.40	159.8	2.2
3	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	65	65	-	-

4	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	22,417.20	9,349.90	-13,067.30	58.3
5	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	26,562.70	19,709.50	-6,853.20	25.8
6	Урьд оны үлдэгдлээс	2,347.00	3,817.00	1,470.00	62.6
7	Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	1,891.50	2,549.30	657.8	34.8
Аймгийн нийт орлого /сумдаас бусад/		80,693.40	63,060.50	-17,632.90	21.9

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ИТХ-ын төсөв батлах, тодотгох тухай тогтоол

1.1.6 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг 19,709.5 сая төгрөгөөр бууруулж, зарим нэр төрлийн орлого болох сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 2,287.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт дүнгээр 17,632.9 сая төгрөгөөр бууруулан, 63,060.5 сая төгрөгөөр баталжээ.

1.2 Орон нутгийн төсвийн орлогын хүрээнд газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйгээс 2,539.2 сая төгрөгийн орлого тасарсан нь төлөвлөсөн орлогын гүйцэтгэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэн байна.

1.2.1 Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дүгээр сарын 29-ны өдрийн 32 тоот тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд 2025 оны төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 88,709.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 86,486.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №4 Төсвийн орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	88,709.70	86,486.40	2,223.30	97
Татварын орлого	45,250.00	44,111.70	1,138.30	97
Татварын бус орлого	14,300.30	13,247.90	1,052.40	93
Хөрөнгө худалдсаны орлого	100	243.8	-143.8	244
Тусламж, санхүүжилтийн орлого	29,059.40	28,883.00	176.4	99

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.2.2 Тайлант оны татварын орлогын гүйцэтгэл 44,111.7 сая төгрөг буюу төлөвлөснөөс 1,138.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №5 Татварын орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Татварын орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан /тасарсан/	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	18,720.2	19,762.2	1,042.0	106
Үйл ажиллагааны орлого	808.8	1,109.4	300.6	137
Хөрөнгийн орлого	2,021.3	1,440.9	(580.4)	71
Хөрөнгө борлуулсны орлого	319.9	420.3	100.4	131
Шууд бус орлого	312.2	469.5	157.4	150
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(993.5)	(993.5)	-	100
ААН-ын орлогын албан татвар	13,900.0	13,462.2	(437.8)	97
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	949.9	1,769.6	819.7	186
Бууны албан татвар	30.5	30.7	0.3	101
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,121.4	911.1	(210.3)	81
Малд ногдуулах албан татвар	820.9	577.3	(243.6)	70
Улсын тэмдэгтийн хураамж	1,106.7	1,560.1	453.4	141

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	16.2	12.8	(3.5)	79
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	331.0	195.1	(136.0)	59
Газрын төлбөр	453.0	696.1	243.2	154
Дуудлага худалдаа	3,500.4	961.2	(2,539.2)	27
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	669.8	462.3	(207.4)	69
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,116.4	1,230.8	114.5	110
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	8.1	33.6	25.5	414
Бусад татвар	37.0	-	(37.0)	-
НИЙТ	45,250.0	44,111.7	(1,138.4)	97

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.2.3 Татварын орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 97 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд дараах нэр төрлийн орлогууд тасарсан байна. Үүнд:

- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг зөвшөөрөл олголтын хэмжээ, ан амьтны нөөцийн ашиглалт, байгалийн нөхцөл байдал, зах зээлийн эрэлт хэрэгцээ зэрэг нөлөөлөх хүчин зүйлд тулгуурласан нарийвчилсан тооцоо, судалгаагүйгээр **669.8 сая төгрөгөөр** төлөвлөсөн нь төлөвлөлтийн бодит байдлыг сулруулж, гүйцэтгэлээр **462.3 сая төгрөг** төвлөрч **207.4 сая төгрөгийн орлого тасрах**, мөн төвлөрсөн орлогын **37 хувь буюу 169.2 сая төгрөг нь төлөвлөгдөөгүй орлого** болох нөхцөл бүрдсэнээр төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдаж, төсвийн удирдлага, хуваарилалтын үр нөлөөнд сөргөөр нөлөөлсөн байна.
- Хөрөнгийн орлогод банкны хадгаламжийн хүү болон хувьцааны ногдол ашгийн орлогыг өмнөх онуудын гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөдөг ба тайлант онд тухайн орлого 580.4 сая төгрөгөөр тасарсан байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого 3.5 сая төгрөгөөр тасарсан нь Баяндэлгэр, Уулбаян, Дарьганга сумдын холбогдох мэргэжилтнүүд төлбөр ногдуулах, хяналт хэрэгжүүлэх ажлыг зохих түвшинд хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.
- *Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 19 хувиар буюу 210.3 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөлтийн алдаанаас шалтгаалсан байна. Аймгийн Татварын газар бүртгэлийн алдаанаас үүссэн ногдлын зөрүүг арилгахаар АТҮТ-тэй хамтран ажиллаж, 339 тээврийн хэрэгслийн хасалт хийсэн байна.*
- *Байгалийн гамшгийн улмаас 2024, 2025 онд сумдын ИТХ-аас малын тоо, толгойд ногдуулах албан татварын хувь хэмжээг тэг төгрөг байхаар тогтоосон байна. Мөн 2021-2023 онуудад үүссэн татварын өр төлбөрийн үлдэгдлийг барагдуулах ажил хангалтгүй байгаатай холбоотойгоор малын тоо, толгойд ногдуулах албан татвар 243.6 сая төгрөгөөр тасрахад нөлөөлсөн байна.*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 437.8 сая төгрөгөөр тасарсан нь аймгийн ИТХ-аас 13,900.0 сая төгрөгөөр баталсан нь нөлөөлсөн.*
- *Газрын дуудлага худалдааны орлого 2,539.2 сая төгрөгөөр тасарсан нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй байна.*
- *Хог хаягдлын хураамж 136.0 сая төгрөгөөр тасарсан нь хог хаягдлын хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг сумдын ЗДТГ хангалтгүй зохион байгуулдаг нь голлон нөлөөлж байна. Иймд Хог хаягдлын тухай хуулийн 29-р зүйлийн 29.2-д "Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч хог хаягдлын хураамжийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна." оруулж 2025 оны 6 сарын 1-ээс хэрэгжүүлэхээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.*

1.2.4 Орон нутгийн төсвийн зарим нэр төрлийн орлогыг төлөвлөхдөө бодит нөхцөл, судалгаа шинжилгээ, татварын баазын мэдээлэл, зөвшөөрөл олголт, ногдуулалт, төвлөрүүлэлт, хяналтын хэрэгжилттэй уялдуулаагүй, мөн холбогдох байгууллага, албан тушаалтнуудын хамтын ажиллагаа, хариуцлага хангалтгүй байснаас орлогын гүйцэтгэлд нийт 4,358.2 сая төгрөгийн тасалдал үүссэн байна. Үүний улмаас төсвийн орлогын

төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдаж, төсвийн тогтвортой байдал сулрах, санхүүжилтийн эх үүсвэрийн дутагдал бий болох, батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт саарах, орон нутгийн хөгжлийн бодлого, үйлчилгээний үр нөлөө буурах сөрөг үр дагавар бий болсон бөгөөд цаашид энэ байдал давтагдвал төсвийн удирдлага, санхүүгийн сахилга бат, орлогын баазын тогтвортой байдалд эрсдэл учруулах нөхцөл хэвээр байна.

1.2.5 Аймгийн 2025 оны татварын орлого 1,138.4 сая төгрөгөөр тасарсан боловч зарим орлого төлөвлөснөөс 3,256.8 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал:

- Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ нэмэгдсэн, газрын төлбөрийн нэхэмжлэх нь газрын албаны мэдээллийн сангаас татварын мэдээллийн сан руу шууд татагддаг. Сумдын газрын даамал гэрээний сунгалт хийх, шинэчлэх ажлыг хангалтгүй хийдгээс бага төлөвлөгдсөн.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 819.7 сая төгрөгөөр давж биелэхэд Цайртминераль ХХК-ы далд уурхайн ажилд үл хөдлөх хөрөнгүүд ашиглалтад орсон нь үл хөдлөх хөрөнгийн албан татвар 819.7 сая төгрөгөөр давж биелэхэд нөлөөлсөн байна.
- Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар өсөхөд төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Газрын төлбөрийн өмнөх онд үүссэн өр төлбөрийг барагдуулсан нь тухайн орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.
- Үйл ажиллагааны орлого 38 хувь буюу 300.6 сая төгрөгөөр давж биелсэнд Баяндэлгэр сум төлөвлөснөөс 4.3 дахин, Онгон сум төлөвлөснөөс 4.8 дахин, Уулбаян сум төлөвлөснөөс 13.5 дахин их буюу нийт төлөвлөсөн дүнгээс 175.8 сая төгрөгөөр орлого төвлөрүүлсэн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

1.2.6 Гэвч салбар хоорондын уялдаа, мэдээлэл солилцооны тогтолцоо хангалтгүйгээс төлөвлөлт үндэслэл багатай хийгдэж, зөрүү ихтэй тооцогдох нөхцөл үүсгэдэг хэвээр байна. Мөн Зарим орлого давж, тасарч байгаа нь төсвийн орлогын бүтэц хэлбэлзэлтэй болсноор зарлагын төлөвлөлтөд хүндрэл үүсгэх үр дагаврыг бий болгож байна.

1.2.7 Татварын бус орлогыг 14,300.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 13,247.9 сая төгрөгийн орлого төвлөрч 93 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №6 Татварын бус орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,300.20	13,247.90	-1,052.30	93
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого	3,364.20	3,469.00	104.8	103
Хүү, торгуулийн орлого	2,793.60	2,899.80	106.2	104
Хувьцааны ногдол ашиг	282.7	31.2	-251.5	11
Бусад орлого	7,859.70	6,847.90	-1,011.80	87

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.2.8 Татварын бус орлого тасрахад дараах хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд:

- Хувьцааны ногдол ашгийн орлогыг Сүхбаатар сум 117.0 сая, Түвшинширээ сум 108.0 сая, Халзан сум 57.7 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн ба гүйцэтгэлээр Түвшинширээ сум 31.2 сая, Халзан сум 33.2 сая нийт 64.4 сая төгрөг төвлөрч, нийт төлөвлөлттэй харьцуулахад 251.5 сая төгрөгөөр орлого тасарсан байна.
- Бусад орлого 1,011.8 сая төгрөгөөр тасарсан нь уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс тасарчээ.

1.2.9 Татварын бус орлогын нөлөөлөл нь төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, гэрээ, хэлцэлд суурилсан орлогын хэрэгжилтэд тавих хяналт сул, орлогын баазыг бодитой үнэлээгүй тохиолдолд цаашид орлогын тасалдал давтагдах, хөрөнгө оруулалт, хөгжлийн

арга хэмжээний хэрэгжилт саарах, орон нутгийн төсвийн удирдлага, санхүүгийн сахилга батад эрсдэл учруулах магадлалыг нэмэгдүүлж байна. Иймд уул уурхайн компаниудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний үүргийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, хэрэгжилтийг баталгаажуулах, биелэлтгүй тохиолдолд хариуцлага, алданги, дараагийн шатны арга хэмжээ авах эрх зүйн нөхцөлийг гэрээнд тодорхой тусган мөрдүүлэх, мөн эрсдэл өндөртэй ийм төрлийн орлогыг төсөвт тусгахдаа бодит боломж, баталгаажсан эх үүсвэрт тулгуурлах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээнд тайлант хугацааны дундуур өөрчлөлт оруулсан нь төслийн хэрэгжилтийн төлөвлөлт, хэрэгжилтийн дараалалд нөлөөлж, иргэдийн оролцоо, итгэлцлийг бууруулах, мөн тухайн жилийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэсэн байна.

2.1 Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 13,067.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг 6,853.2 сая, нийт 19,920.5 сая төгрөгийг бууруулж баталсан байна.

2.1.1 Аймгийн ИТХ-ын 2025 оны 04 сарын 14-ний өдрийн 12 тоот тогтоолоор Төсвийн тухай хуулийн 64 дугаар зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн дараах арга хэмжээнүүдэд өөрчлөлт хийсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Туулах чадвартай автомашинаар хангах”, “Зураг төсөв боловсруулах зардал”, “Талын наран зохиолч яруу найрагчдын цэцэрлэгт хүрээлэн”, “Шинэ суурьшлын бүс байгуулах”, “Ургах наран хорооллын автозам”, “Чип төслийн цахилгаан хангамжийн дэд станц худалдан авах”, “Амгалан гэр хорооллын шугам сүлжээний ажлын зураг”, “Адапт төслийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд орон нутгийн оролцоо”, “Сумын төвийн хатуу хучилттай зам шинээр барих” арга хэмжээний нийт 1,848.6 сая төгрөг хасаж, “Өрхийн эмнэлгийн барилга”, “Чип төслийн цахилгаан хангамжийн дэд станц худалдан авах”, “Ирэх жилүүдэд ажлын зураг төсөв боловсруулах”, “Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хурлын зориулалттай таблет худалдан авах”, “Сургуулийн спорт заалны их засвар” гэсэн 1,672.4 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тодотгосон байна.

- Орон нутгийн хөрөнгө оруулалт арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчдын орон сууц барих” арга хэмжээний санхүүжилт 640.0 сая төгрөгийг хасаж, “Мал эмнэлгийн лабораторийг биохимийн шинжилгээ хийх тоног төхөөрөмжөөр хангах”, “Багийн төвийн өргөтгөл, шинэчлэлт”, “Сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах” арга хэмжээний нийт 128.2 сая төгрөгийг нэмж өөрчлөхөөр зохицуулалт хийсэн байна.

- Замын сангаас “авто замын хэсэгчилсэн засвар, арчлалт, нөхөөс ус зайлуулах хоолой барих” төсөл арга хэмжээний 9.0 сая, “Аймгийн төвийн авто замын засвар, арчилгаа” арга хэмжээнд 100.0 сая, “Нийгмийн даатгалын газрын зүүн урд уулзвараас Асгат сумын чиглэлд гарах замын засвар шинэчлэлт /Баруун-Урт сум/” арга хэмжээнд 396.0 сая, нийт 505.0 сая төгрөг нэмсэн.

- Их засварын зардлын “Өвсний үндэс төслийн аймгийн оролцоо” арга хэмжээний 132.0 сая төгрөгийн хасаж, “Аймгийн нэгдсэн эмнэлгийн дээврийн болон их засварын ажил”, “Спорт заалны дээврийн засвар” гэсэн арга хэмжээний нийт 315.0 сая төгрөгийг нэмж өөрчлөлт оруулсан байна.

2.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээг тайлант хугацааны дундуур өөрчлөн, шинэ төсөл, арга хэмжээг тусгаж, эхний байдлаар төлөвлөгдсөн зарим төслийг хассан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний журам”-ын 7.6, 7.7 дахь заалтыг зөрчсөн бөгөөд энэ нь иргэдийн оролцоонд үндэслэн хэрэгжүүлэх ёстой төсвийн зарцуулалтын ил тод,

хариуцлагатай байдлыг алдагдуулах, иргэдийн оролцоог бууруулах, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөө, тайлангийн хооронд зөрүү үүсгэх, сэргээр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

2.1.3 Аймгийн ИТХ-ын 2025 оны 06 сарын 05-ний өдрийн 21 тоот тогтоолоор Төсвийн тухай хуулийн 64 дугаар зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн дараах арга хэмжээнүүдэд өөрчлөлт хийсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Чип төслийн цахилгаан хангамжийн дэд станц худалдан авах”, “Хүнсний лабораторийн тоног төхөөрөмж”, “Газар чөлөөлөлт”, “АНЭ-ийн тоног төхөөрөмж”, “Цахим үндэстэн хөтөлбөрийн хүрээнд хурлын зориулалттай таблет худалдан авах” арга хэмжээний нийт 361.0 сая төгрөг хасаж, “Түмэнцогт сумын уурын зуухны тогооны шинэчлэл оролцоо”, гэсэн 61.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тодотгосон байна.
- Замын сангаас “Аймгийн төвийн авто замын засвар, арчилгаа” төсөл арга хэмжээний 300.0 сая төгрөг нэмсэн байна.

2.1.4 Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн 64 дугаар зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн дараах арга хэмжээнүүдэд өөрчлөлт хийсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих нийт 4,039.1 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээг хассан.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” арга хэмжээнээс 1,702.1 сая төгрөг хассан.
- Их засварын зардлаас “Сургуулийн байрны их засвар” төсөл арга хэмжээний 500.0 сая төгрөг хассан байна.

2.1.5 Мөн аймгийн ИТХ-ын 2025 оны 7 сарын 29 өдрийн 32 дугаар тогтоолоор ИТХ-ын зардал 308.8 сая, Засаг даргаас 10,654.8 сая, Монгол Улсын төсөвт төлөх зээлийн эргэн төлөлт, зээл хүүгийн төлбөр 428.0 сая, нийт 11,391.6 сая төгрөгийн урсгал зардлыг бууруулж баталжээ.

2.2 Орон нутгийн төсвийн зарлагын бүтцэд урсгал зардал 64.3 хувь, хөрөнгийн зардал 34.9 хувь, цэвэр зээл 0.9 хувийг тус тус эзэлж байгаа нь төсвийн ихэнх хэсэг нь урсгал зардалд чиглэж, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын чиглэлийн санхүүжилт харьцангуй бага байгааг илтгэж байна.

2.2.1 Сүхбаатар аймгийн 2025 оны төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 83.029,5 сая төгрөг буюу 75.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №7 Төсвийн зарлагын гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Б	1	2	3	4	5=3-4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,862.70	109,461.1	83,029.5	26,431.6	75.9
УРСГАЛ ЗАРДАЛ	52,384.30	61,405.1	53,372.6	8,032.5	86.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,512.10	57,662.4	50,153.8	7,508.6	87.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,749.30	20,558.0	19,308.9	1,249.0	93.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,040.00	2,555.4	2,367.5	187.8	92.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,858.50	12,060.9	11,484.0	576.9	95.2
Хангамж, бараа материалын зардал	942.6	1,005.5	765.5	240.0	76.1

Нормативт зардал	18.0	245.5	236.2	9.2	96.2
Эд хогшил, урсгал засварын зардал	1,376.60	1,711.8	1,532.5	179.3	89.5
Томилолт, зочны зардал	427.3	483.6	356.0	127.6	73.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,010.40	7,683.6	6,801.6	882.0	88.5
Бараа үйлчилгээний бусад зардал	11,387.40	11,358.2	7,301.5	4,056.7	64.3
ТАТААС	1,446.90	1,302.6	1,260.0	42.6	96.7
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	712.5	232.6	200.0	32.6	86.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	734.4	1,070.0	1,060.0	10.0	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768.4	1,070.0	1,060.0	10.0	99.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,978.1	2,440.2	1,958.9	481.3	80.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	500.2	44,259.8	28,946.8	15,313.0	65.4
Эргэж төлөгдөх зээл	500.2	3,796.2	710.0	3,086.1	18.7

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.2.2 Орон нутгийн 2025 оны төсвийн зарлага 83,029,5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй бөгөөд үүнээс бараа, ажил үйлчилгээний зардал 53,372.6 сая, татаас 1,260.0 сая, урсгал шилжүүлэг 1,958.9 сая, хөрөнгийн зардал 28,946.8 сая, эргэж төлөгдөх зээл (ХХС, ЖДҮ-ийн сан) 710.0 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

2.2.3 Дор дурдсан аудитын илрүүлэлтүүд нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын шаардлагад бүрэн нийцээгүй боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч тусгасан байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг баталгаажуулах аудитаар дараах эрх зүйн актын зөрчилтэй гүйцэтгэлүүд тусгагдсан байна. Үүнд:

- **Мөнгөн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой** нийт 2,025.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, хуульд нийцэхгүй тэтгэмж, урамшуулал олгосон, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, төрд учруулсан хохирлыг нөхөн барагдуулаагүй зэрэг асуудал хамаарч байна.
- **Төсвийн зарцуулалт, орлогын бүртгэлтэй холбоотой** нийт 166.6 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд цалин хөлс, нэмэгдлийг илүү, дутуу бодож олгосон, төсвийн хөрөнгөөр тэмцээн, уралдаан зохион байгуулсан, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, үндсэн үйл ажиллагаанд хамаарахгүй зарцуулалт гаргасан, зардлыг зохих журмаар баталгаажуулаагүй асуудал хамаарч байна. Энэ нь төсвийн зориулалт, хууль тогтоомжийн нийцэл, зардлын бодит байдалд сөргөөр нөлөөлж байна.
- **Авлага, өр төлбөр данстай холбоотой нийт 9.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд үүнд** Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй бодит бус авлага үүсгэсэн, өр төлбөрийг дутуу бүртгэсэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- ОНӨҮГ-уудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг шалгуур үзүүлэлтээр үнэлж, үр ашиггүй, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжгүй нэгжүүдэд хуулийн дагуу дүн шинжилгээ хийж, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах асуудлаар аймгийн Засаг дарга, холбогдох газарт зөвлөмж чиглэл хүргүүлэн ажилласан. Гэвч аймаг, орон нутгийн төсвийн санхүүгийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж буй Сүхбаатар тохижилт үйлчилгээ, Сүхбаатар соёл амралтын хүрээлэн, Чоногол тохижилт, Сүхбаатар нийтлэг үйлчилгээ, Уртын гэгээ, Сүхбаатар хөгжил ҮТП, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨҮГ-уудын харилцах дансанд нийт 624.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь тухайн байгууллагуудын орлого, зардлын төлөвлөлт бодитой бус, санхүүгийн менежмент сул, мөнгөн хөрөнгийг үр ашиггүйгээр байршуулах, санхүүгийн сахилга бат алдагдсан

байгааг харуулж байна. Мөн Эрдэнэцагаан сумын хот тохижилтын чиг үүргийг Чоногол хөгжил ОНӨҮГ-т шилжүүлэн хэрэгжүүлэх бодит нөхцөл, боломжийг бүрдүүлэлгүйгээр Чоногол тохижилт ОНӨҮГ-ыг шинээр байгуулж, ОНХС-ийн зориулалт, чиг үүрэгт үл хамаарах ажил үйлчилгээг тус хөрөнгөөр санхүүжүүлсэн нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, төлөвлөлтгүй зарцуулж, санхүүгийн сахилга бат алдагдуулах, улмаар орон нутгийн төсөвт бодит ачаалал үүсгэх сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлийг бий болгосон байна.

- Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу аймгийн баяр наадмын зардлыг 10.0 сая төгрөгөөр тогтоосон боловч одоогийн нөхцөл байдал, бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс шалтгаалан тухайн санхүүжилт нь баяр наадмын зардлыг бүрэн хангаж чадахгүй байна. Аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн баяр наадмын зардалд 250.0 сая төгрөг баталж, зарцуулсан байна. Иймд Засгийн газрын тогтоолыг инфляцын түвшинтэй уялдуулан өөрчлөх шаардлага үүссэн байна.
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бүртгэлийн мэргэжилтэн зэрэг төрийн захиргааны албан хаагчдад нийт 17.6 сая төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасны дагуу, мөн Төрийн албаны зөвлөлөөс хянаж баталгаажуулсан ажлын байрны тодорхойлолтод тухайн албан тушаалд мэргэшсэн нягтлан бодогч байх шаардлага тавигдсантай нийцүүлэн хэрэгжүүлсэн байна.
- Түвшинширээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд 23.5 сая төгрөгийг төсвөөс олгосон. Уг асуудлаар ИТХ-ын шийдвэрийг нууц санал хураалтаар гаргасан бөгөөд нууц санал хураалтын хурлын протокол бүрдээгүй тул шийдвэр гаргасан төлөөлөгчдөд хариуцлага тооцох, буруутай этгээдээр төсвийн хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардагдах анхан шатны баримт, шийдвэрийн нотлох бүрдэл тогтоогдоогүй байна. Үүний улмаас дээрх зардал төсвийн гүйцэтгэлд тусгагдан баталгаажсан
- Дээрхээс дүгнэхэд, баяр наадмын санхүүжилтийн жишиг хэмжээ, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олголтын зохицуулалт, мөн ОНӨҮГ-ын байгуулалт, санхүүжилт, гүйцэтгэлийн шалгууртай холбоотой эрх зүйн болон дотоод зохицуулалтыг өнөөгийн эдийн засаг, төсвийн бодит нөхцөлтэй нийцүүлэн илүү тодорхой, нэг мөр болгож шинэчлэх шаардлагатай байна. Ингэснээр төсвийн төлөвлөлт, зарцуулалтын бодит байдал, ил тод байдал, хариуцлага дээшилж, орон нутгийн өмч, төсвийн хөрөнгийн үр ашигтай, сахилга баттай удирдлагыг хангах боломж бүрдэх юм. Эрх зүйн актад өөрчлөлт оруулах талаарх саналыг аудитын тайлангийн санал хэсэгт авч үзсэн.

БҮЛЭГ 3. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 376 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 56.7 хувьтай байгаа нь төсвийн хүндрэлээс гадна зураг төсөв, худалдан авах ажиллагаа, байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байсантай холбоотой бөгөөд хөрөнгө оруулалтын төсөв бүрэн ашиглагдахгүй үлдэх, иргэдийн эрэмбэлсэн ажлууд хойшлох, төрийн үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмж саарах сөрөг үр дагавар үүсгэж байна.

3.1 Тайлант онд 350 төсөл, арга хэмжээг 38,599.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталсан бөгөөд гүйцэтгэл 55.5 хувь буюу гүйцэтгэл 21.427.5 сая төгрөг байна.

Хүснэгт № 8 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сумын нэр	TAX /тоо/	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Асгат сум	20	1,506.10	940.9	699.9	-241.05	74.4
2	Баруун-Урт сум	38	6,350.90	5,611.30	3,436.00	-2,175.26	61.2

3	Баяндэлгэр сум	36	1,831.30	1,831.30	712.9	-1,118.37	38.9
4	Дарьганга сум	21	1,057.10	1,057.10	797	-260.05	75.4
5	Мөнххаан сум	32	2,144.70	1,656.10	1,258.30	-397.78	76
6	Наран сум	9	1,235.10	413.1	228.5	-184.55	55.3
7	Онгон сум	17	1,524.40	1,442.80	910.9	-531.81	63.1
8	Сүхбаатар сум	23	10,171.50	4,623.20	1,705.60	-2,917.60	36.9
9	Түвшинширээ сум	31	1,221.00	1,563.00	725.8	-837.2	46.4
10	Түмэнцогт сум	18	846.1	846.1	588.7	-257.43	69.6
11	Уулбаян сум	14	805.7	771.4	86.9	-684.45	11.3
12	Халзан сум	11	743.8	743.8	507.1	-236.62	68.2
13	Эрдэнэцагаан сум	36	7,744.60	4,232.50	1,752.20	-2,480.33	41.4
	Сумдын дүн	306	37,182.30	25,732.50	13,410.00	-12,322.50	52.1
	Аймгийн дүн	44	30,115.30	12,867.00	8,017.50	-4,849.46	62.3
	Нийт дүн	350	67,297.70	38,599.40	21,427.50	-17,171.95	55.5

3.1.1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан өмнөх оноос шилжиж буй 34, шинээр хэрэгжих 10 нийт 44 төсөл, арга хэмжээнд 38,599.4 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс, 21,427.5 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж, гүйцэтгэл 55.5 хувийн биелэлттэй байна. Төсөл арга хэмжээний гүйцэтгэл бага байгаа нь төслийн техникийн болон зураг төслийн баримт бичиг бүрдээгүй, төсвийн орлого дутуу бүрдсэн, төлөвлөлт хангалтгүй байсан, худалдан авах ажиллагааны хүрээнд зарим төсөлд тендер шалгаруулалт зарлагдаагүй эсхүл удаашралтай явагдсан, мөн орон нутгийн байгууллагуудын хэрэгжилтийг хариуцах ажлын зохион байгуулалт, хяналт, хамтын ажиллагаа сул байсантай холбоотой байна.

3.1.2 Тухайн жилд хэрэгжих 4 төсөл, арга хэмжээний 296.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, 12 төсөл, арга хэмжээ 5-70 хувь буюу 3,751.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь холбогдох баримт бичиг дутуугаас худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тендер зарласан боловч амжилтгүй болсон, бүрэн хэрэгжээгүй, техникийн тодорхойлолтод заасан шалгуур, нөхцөлд нийцээгүй, гэрээг дүгнэж, улсын комисс хүлээж аваагүйтэй холбоотой байна.

3.1.3 Эдгээр нөхцөл нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, зарим ажил хугацаандаа эхлэхгүйгээс үүдэн тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөв бүрэн ашиглагдахгүй байх, иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн зорилтот ажлууд хэрэгжихгүй үлдэх, улмаар олон нийтэд чиглэсэн үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмж саатах, иргэдийн оролцоонд суурилсан төсвийн зарцуулалт, итгэлцэлд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн сахилга, төсвийн төлөвлөлтийн бодит байдалд эрсдэл учруулах зэрэг сөрөг үр дагавар үүсгэх нөхцөл бүрдүүлж байна.

3.1.4 Сумдын түвшинд төсөв, төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа, санхүүгийн сахилга бат, хяналт хариуцлага хангалтгүй байгаагаас зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, зарцуулалтын үр ашиг алдагдсан, төрийн бодлогын хэрэгжилт саатах нөхцөл бүрдсэн байна.

3.2 Их засварын чиглэлээр хэрэгжүүлэх нийт 10 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн боловч Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласнаас шалтгаалан санхүүжилтийг дутуу олгосон байна.

3.2.1 Аймгийн их засварын хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 8 төсөл, арга хэмжээг 1,613.2 сая, шинээр хэрэгжиж буй 2 төсөл, арга хэмжээг 3,434.0 сая нийт 5,047.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт №9 Их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Гүйцэтгэл
1	Шилжих хөрөнгө оруулалт				
1.1	Соёлын төвийн барилгын их засварын ажлын санхүүжилт / Асгат сум/	2020-2024	201.6	10.0	-
1.2	Сургуулийн гадна дулаалгын их засвар / Баруун-Урт сум, 2-р сургууль/	2023-2024	510.0	22.9	-
1.3	Сургуулийн барилгын их засвар /Асгат сум/	2024	500.0	23.7	-
1.4	Аймгийн нэгдсэн эмнэлгийн дээврийн болон их засварын ажил /Өвсний үндэс төслийн аймгийн оролцоо /	2024	1,108.0	312.0	-
1.5	Сумын Эрүүл мэндийн төвийн их засвар /Онгон сум/	2024	475.0	23.40	-
1.6	Дулааны станцын 1-р зуухны их засвар	2024-2025	1,700.0	84.9	
1.7	Дулааны станцын 2-р зуухны их засвар	2024-2025	1,134.0	1,133.4	740.0
1.8	Спорт заалны дээврийн засвар /Түмэнцогт сум/	2023-2025	50.0	2.9	2.4
	ДҮН		5,678.6	1,613.2	742.4
2	Шинэ хөрөнгө оруулалт				
2.1	Сургуулийн барилгын их засвар /Баруун-Урт сумын 1-р сургууль/	2025-2026	3,000.00	2,500.0	2,212.5
2.2	Цэцэрлэгийн барилгын их засвар /Эрдэнэцагаан сум, 2-р цэцэрлэг/	2025-2026	1,300.00	934.00	755.2
	ДҮН		4,300.00	3,434.0	2,967.7
	НИЙТ ДҮН		9,978.60	5,047.2	3,710.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

3.2.2 Тайлант онд их засварын зардлаар хэрэгжүүлэхээр 10 төсөл, арга хэмжээнд нийт 5,047.2 сая төгрөгийн хөрөнгө батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 4 төсөл, арга хэмжээнд 3,710.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

3.2.3 Баруун-Урт сум, 2-р сургуулийн гадна дулаалгын их засвар, Асгат сумын Соёлын төвийн барилгын их засвар, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар, Аймгийн нэгдсэн эмнэлгийн дээврийн болон их засварын ажил, Ongon сумын Эрүүл мэндийн төвийн их засвар, Дулааны станцын 1-р зуухны их засварын ажлын гүйцэтгэл бүрэн дууссан боловч тайлант онд санхүүжүүлэх нийт 476.9 сая төгрөг олгоогүй байна.

3.2.4 Дулааны станцын 2-р зуухны их засвар, Түмэнцогт сумын спорт заалны дээврийн засвар, Баруун-Урт сумын 1-р сургуулийн барилгын их засвар, Эрдэнэцагаан сумын 2-р цэцэрлэгийн барилгын их засварын ажлын тайлант онд төлөвлөснөөс дутуу буюу 65-86 хувиар санхүүжилтийг олгосон байна.

3.2.5 Их засварын чиглэлээр хэрэгжүүлэх нийт 10 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн боловч Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласнаас шалтгаалан санхүүжилтийг дутуу олгосон байна.

3.2.6 Дээрх санхүүжилтийг дутуу олгосон нь Сангийн яамнаас зарцуулах эрхийг хязгаарласантай холбоотой байна.

3.3 Орон нутгийн хөрөнгө оруулалт 75.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

3.3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн 6, шинээр хэрэгжих 2 төсөл, арга хэмжээг 1,307.3 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт № 18 орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	хувь
1	Шилжих хөрөнгө оруулалт					
1.1	Тоног төхөөрөмж худалдан авах /Жаахан шарга ХЖТ/	2024-2025	76.0	3.8	3.8	100
1.2	Бэлчээрийн менежментийг сайжруулах хүрээнд хадлан тэжээлийн нөөц газар байгуулах /Адап төслийн оролцоо/	2024-2025	378.1	113.4	104.7	92.3
1.3	Төрийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд автомашин худалдан авах /Аймгийн ЗДТГ/	2024-2025	80.0	4.0	4.0	100
1.4	Мал эмнэлгийн лабораторийг биохимийн шинжилгээ хийх тоног төхөөрөмжөөр хангах	2023-2025	68.7	3.4	0.0	0
1.5	Багийн төвийн өргөтгөл, шинэчлэлт/ Баяндэлгэр сум, Хонгор баг/	2023-2025	250.0	12.3	0.0	0
1.6	Сумдын Засаг даргын тамгын газарт автомашин худалдан авах/ 10 сум/	2023-2025	2250.0	112.5	112.5	100
	ДҮН		3,102.8	249.4	225.0	90.2
2	Шинэ хөрөнгө оруулалт					
2.1	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	2025	1,860.0	202.9	0	0
2.2	Төрийн албаны машины парк шинэчлэлийн хүрээнд автомашин худалдан авах	2025-2026	900.0	855.0	761.8	89.1
			2,760.0	1,057.9	761.8	72.0
	НИЙТ ДҮН		5,862.8	1,307.3	986.8	75.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

3.3.2 Тайлант онд нийт 8 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 3 нь бүрэн хэрэгжиж, 2 арга хэмжээ 89.1-92.3 хувийн гүйцэтгэлтэй, 2 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үл хэрэгжсэн болон гүйцэтгэл хангалтгүй байгаа арга хэмжээнүүд нь орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотойгоор санхүүжилтийг эрэмбэлэн олгосны үр дагавар юм.

3.4 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 84.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.4.1 Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 5, шинээр хэрэгжүүлэх 3 нийт 4,712.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг 3.089.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан.

Хүснэгт №11 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ий гүйцэтгэл /сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих тодотгосон дүн	Гүйцэтгэл	Хувь
1	Шилжих хөрөнгө оруулалт					
1.1	Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртэлх хатуу хучилттай автозам / Баруун-Урт сум,/	2022-2025	751.8	51.0	-	-
1.2	Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай автозам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар, нөхөөс /2-р тойрог/	2022-2025	180.0	72.8	52.3	71.8
1.3	Эко хорооллын автозамын ажил / Баруун-Урт сум, 7-р баг/	2023-2025	500.0	106.0	0.0	0.0
1.4	Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зам	2024-2025	564.0	420.1	391.4	93.2

1.5	Авто замын хэсэгчилсэн засвар, арчлалт, нөхөөс ус зайлуулах хоолой барих(Баруун-Урт сум)	2024-2025	192.0	9.0	0.0	0.0
ДҮН			2,187.8	658.9	444	67.3
2	Шинэ хөрөнгө оруулалт					
2.1	Боловсрол хорооллын хойд хэсгийн авто замын зогсоол	2025	130.0	130.0	-	-
2.2	Нийгмийн даатгалын хэлтсийн зүүн урд уулзвараас Асгат сумын чиглэлд гарах замын засвар шинэчлэлт /Баруун-Урт сум/	2025-2026	1,894.9	1,800.1	1,695.2	94.2
2.3	Аймгийн төвийн авто замын засвар, арчилгаа	2025	500.0	500.0	465.4	93.1
ДҮН			2,524.9	2,430.1	2,160.6	88.9
НИЙТ ДҮН			4,712.7	3,089.0	2,604.3	84.3

сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

3.4.2 Тайлант онд авто замын сангийн санхүүжилтийн гүйцэтгэл 2,604.3 сая төгрөг буюу 84.3 хувийн биелэлттэй байна.

3.4.3 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 8 төсөл арга хэмжээний 6 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан ба 2 төсөл арга хэмжээ /Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртэлх хатуу хучилттай автозам, Эко хорооллын автозамын ажил/ 95 хувийн хэрэгжилттэй байна.

БҮЛЭГ 4. Орон нутгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээ, шалгуур үзүүлэлтүүдийг төсвийн төсөлтэй уялдуулан тайлагнаж, тайланг ИТХ-аар “Хангалттай” гэж үнэлсэн боловч зарим арга хэмжээний хэрэгжилт харилцан адилгүй байгаа нь төсөв, үр дүнгийн хамаарлыг илүү бодитой үнэлэх, хэрэгжилтийн тайлагналыг чанаржуулах шаардлагатайг харуулж байна.

4.1 Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн тайлагнасан байна.

4.1.1 Сүхбаатар аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангаар 27 хөтөлбөр, арга хэмжээнд 94,308.4 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 78.4 хувьтай байна.

Хүснэгт№ 12 Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/ (сая төгрөг)

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
70105-ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	4,939.86	4,424.44	515.4	89.6
70106-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	85,437.18	63,887.80	21,549.4	74.8
70410-Төрийн архив, албан хэрэг хөтлөлт	87.17	79.06	8.1	90.7
70417-Худалдан авах ажиллагаа	388.79	343.03	45.8	88.2
70425-Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	439.41	439.32	0.1	100.0
70428-Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага	633.79	591.47	42.3	93.3
70504-Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	2,549.31	2,549.31	-	100.0
70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх	400.00	245.44	154.6	61.4
70709-ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	454.36	432.80	21.6	95.3
70800-Сургуулийн өмнөх боловсрол	434.44	343.18	91.3	79.0
71101-Авто зам	3,089.04	2,604.27	484.8	84.3
71402-Ойжуулалт	688.47	665.21	23.3	96.6
71406-Хүрээлэн буй орчны бохирдол	2,473.09	2,403.09	70.0	97.2
71410-Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,309.80	1,108.47	201.3	84.6
71413-Байгаль хамгаалах, нөхөн сэргэх хөтөлбөр	247.07	160.57	86.5	65.0
71506-Суурин газрын усан хангамж	232.57	200.00	32.6	86.0
71508-Гудамжны гэрэлтүүлэг	1,192.23	1,105.48	86.8	92.7
71602-Эрүүл мэнд	2,131.51	2,005.69	125.8	94.1

71701-Биеийн тамир, спорт	924.98	924.98	-	100.0
71702-Соёл урлаг	1,401.62	1,270.97	130.6	90.7
71801-Сургуулийн өмнөх боловсрол	1,880.04	1,776.82	103.2	94.5
71802-Ерөнхий боловсрол	5,022.08	4,882.32	139.8	97.2
71804-Мэргэжлийн боловсрол	355.38	311.48	43.9	87.6
71901-Нийгмийн халамж	213.26	191.43	21.8	89.8
72101-Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	3,075.37	1,020.54	2,054.8	33.2
72207-Хүүхдийн хөгжил хамгаалал	180.00	180.00	-	100.0
72208-Ахмад настны хөгжил хамгаалал	163.11	162.20	0.9	99.4
НИЙТ ДҮН	120,343.9	94,309.4	26,034.6	78.4

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4.1.2 Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэн батлуулж, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнасан байна.

4.2 Сүхбаатар аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний тайланг Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2025 оны 46 дугаар тогтоолоор нийт төлөөлөгчдийн 96.2 хувийн саналаар “Хангалттай” гэж үнэлжээ.

4.2.1 Сүхбаатар аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 8 зорилт, 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, гүйцэтгэлийг 86.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Хүснэгт № 13 Хөгжлийн төлөвлөгөөний биелэлт (сая төгрөг)

№	2025 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилт	Төлөвлөгөө	Биелэлт хувиар				Дундаж хувь	Төсөв	Зарцуулсан төсөв
			0-25	26-50	51-75	76-100			
1	Үндсэн үнэт зүйл	5			1	4	90	4,708.20	1,871.10
2	Хүний хөгжил	24	1	2	2	19	87	36,360.40	44,733.30
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	21	3	1	2	15	77	23,390.50	19,506.70
4	Эдийн засаг	17		1	1	15	93	57,050.00	39,032.70
5	Засаглал	24			1	23	99	13,539.90	8,950.90
6	Ногоон хөгжил	13	1	1		11	87	11,439.80	1,270.60
7	Амар тайван аюулгүй нийгэм	3	1			2	66	700	1,709.00
8	Бүс, орон нутгийн хөгжил	7			1	6	93	1,096.00	1,103.40
	Нийт	114	6	5	8	95	86.5	148,284.80	118,177.70

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс

4.2.2 Сүхбаатар аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 114 арга хэмжээнд улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нийт 148,284.9 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 118,177.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.2.3 Төлөвлөсөн нийт 114 арга хэмжээний 95 нь 76-100 хувийн, 8 нь 51-75 хувийн, 5 нь 26-50 хувийн, 60-25 хувийн хэрэгжилттэй байгаа нь зарим арга хэмжээний хэрэгжилтэд ахиц гарсныг харуулж буй хэдий ч 6 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь төсөв, төлөвлөлт, тендерийн үйл явц, хэрэгжилтийн зохион байгуулалт хангалтгүй байсныг илтгэж, үр дүнд суурилсан үнэлгээ хийх, бодит хэрэгжилтийн түвшнийг тодорхойлох боломжийг хязгаарлаж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөнд сөргөөр нөлөөлсөн байна.

БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, зарцуулсан боловч нэмэлт орлогын бүтэц, зориулалт, үлдэгдлийн удирдлагад хяналтыг тогтмол хэрэгжүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого, хандив, дээд шатны шилжүүлгийн бүртгэл, тайлагналыг илүү нэгдсэн байдлаар сайжруулах шаардлагатай байна.

5.1 Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны нэмэлт төсөвт ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 303.1 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 108.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 145.7 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 734.9 сая нийт 1,291.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

5.2 Нэмэлт төсвөөр бүрдүүлсэн эх үүсвэрийг эдийн засгийн ангиллаар дараах зардлуудад 825.2 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 466.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №14 Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)

Зардлын үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	825.2
УРСГАЛ ЗАРДАЛ	825.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17.8
Хангамж, бараа материалын зардал	62.3
Нормативт зардал	0.3
Эд хогшил, урсгал засварын зардал	27.1
Томилот, зочны зардал	12.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	202.5
Бараа үйлчилгээний бусад зардал	402.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28.2
Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	466.5
Төвлөрүүлэх шилжүүлэг	466.5

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗД-ын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

5.3 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод сумдын өвс тэжээлийг худалдан борлуулсны орлого, ухаалаг худгийн усны төлбөрийн орлогууд эзэлж байна. Нэмэлт төсвийн 96.5 хувийг бараа ажил үйлчилгээний зардалд, 3.5 хувийг урсгал шилжүүлэгт тус тус зарцуулжээ.

БҮЛЭГ 6. Шилэн данс, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий судалгаа

6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

6.1.1 Төсөв захирагч нар Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

6.1.2 Төсөв захирагч нар Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг бүрэн хангаагүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил давтан гарч, тайлант хугацаанд СХДАА-ны хяналтаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн 20, төсвийн шууд захирагчийн 31, ОНӨААТҮГ-ын 14, нийт 65 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд байршуулаагүй нь ил тод байдал, хариуцлагын тогтолцоо сул, дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байгааг харуулж байна.

6.1.3 Энэ нь төсөв, санхүүгийн мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, хугацаанд нь нийтлэх хуулийн шаардлага зөрчигдөх, иргэдийн мэдээлэл авах эрх хязгаарлагдах, төсвийн зарцуулалтад тавих олон нийтийн хяналт сулрах, зөрчил дутагдал давтагдах нөхцөл бүрдэхэд нөлөөлж байна.

6.1.4 Иймд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг зөвхөн зөвлөмжөөр хязгаарлахгүйгээр тайлант хугацааны давтамжтай хяналт, хариуцлагын механизм, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулан сайжруулж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн байршуулах үүргийн хэрэгжилтийг байгууллага, албан тушаалтан бүрээр тодорхой хариуцуулан хэвшүүлэх шаардлагатай байна.

6.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Аудитын илрүүлэлт:

6.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 54.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 32.2 сая төгрөгийн 12 төлбөрийн акт тогтоож, 22.5 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг залруулах 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд: Зөрчлийг агуулгаар нь ангилж харуулбал:

- Төсвийн хөрөнгөөр спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан, Төрийн албан хаагчдын нэгдсэн тэмцээнд оролцоход төсвөөс 33.0 сая төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. /Асгат, Баруун-Урт, Мөнххаан, Наран, Онгон, Түвшинширээ, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумын ЗДТГ, Баруун-Урт, Онгон ИТХ/
- Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгсэлд тод өнгийн улсын дугаар хэрэглээгүй байна. /Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагч ОНӨААТҮГ/
- Төсвөөс 1.5 сая төгрөгөөр архи согтууруулах ундаа худалдан авсан. /Түвшинширээ сумын ЗДТГ/
- Төсвөөс 3.6 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан. /Наран, Сүхбаатар сумын ИТХ, Эрдэнэцагаан сумын ЗДТГ/
- Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр 16.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон. /Асгат, Сүхбаатар сумын ЗДТГ/

6.2.2 Эдгээр зөрчлүүд нь төсвийн хяналт, санхүүгийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сулруулж, үр ашиггүй зарцуулалтыг үүсгэн, санхүүгийн зохицуулалтын алдаа болон төрийн сангийн удирдлагын системд эрсдэл үүсгэсэн бөгөөд, үүнээс үүдэн төсвийн хөрөнгийг буруу чиглэлд зарцуулж, төрийн хэмнэлтийн бодлого зөрчигдөж, төсвийн гүйцэтгэлийн зарим зарлагыг зохисгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй зардалд зарцуулж, санхүүгийн бүтцийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

6.3 Ерөнхий чиглэлийн судалгааны талаар:

6.3.1 УНАА, ХООЛНЫ ХӨНГӨЛӨЛТИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭНИЙ СУДАЛГАА

Аймгийн засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад 32 байгууллага хамрагдсан бөгөөд унаа, хоолны хөнгөлөлт олгосон судалгааг иж бүрэн ирүүлсэн.

Хоолны хөнгөлөлт: Судалгаанд нийт 32 байгууллага хамрагдсанаас 29 байгууллага хоолны хөнгөлөлт олгодог ба 3 байгууллага (Баяндэлгэр сумын ИТХ, ЗДТГ) хоолны хөнгөлөлт олгоогүй байна.

Судалгаанд хамрагдсан аймгийн ТЕЗ-ын харьяа байгууллагууд унаа, хоолны хөнгөлөлтийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол, салбарын сайд болон агентлагийн даргын тушаал, мөн байгууллагын дотоод журам, хамтын гэрээнд үндэслэн олгож байна. Аймгийн Засаг даргын харьяаны байгууллагуудын нэгтгэсэн дүнгээр хоолны хөнгөлөлтийн тариф 3,000-30,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж, дундаж хэмжээ 10,518 төгрөг байна. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын 10 хувь нь 20,000-30,000 төгрөг, 58 хувь нь 10,000-15,000 төгрөг, 26 хувь

нь 3,000-8,000 төгрөгийн хоолны хөнгөлөлт олгож байгаа бөгөөд доод түвшин 3,000 төгрөг, дээд түвшин 30,000 төгрөг байна. Энэ нь аймгийн хэмжээнд хоолны хөнгөлөлт олгох нэгдсэн бодлого, жигд зохицуулалт бүрдээгүй, байгууллага бүр дотоод зохицуулалтаараа ялгаатай хэрэгжүүлж байгааг харуулж байна.

Унааны хөнгөлөлт: Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас унааны хөнгөлөлт олгож буй байгууллага байхгүй байна.

6.3.2 ТӨРД УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ГАРСАН ЗАРДЛЫН СУДАЛГАА

Түвшинширээ сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлсөнд 23.5 сая төгрөгийг төсвөөс олгосон. Уг асуудлаар ИТХ-ын шийдвэрийг нууц санал хураалтаар гаргасан бөгөөд нууц санал хураалтын хурлын протокол бүрдээгүй тул шийдвэр гаргасан төлөөлөгчдөд хариуцлага тооцох, буруутай этгээдээр төсвийн хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардагдах анхан шатны баримт, шийдвэрийн нотлох бүрдэл тогтоогдоогүй байна. Үүний улмаас дээрх зардал төсвийн гүйцэтгэлд тусгагдан баталгаажсан.

Дарьганга сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнийг тухайн албан тушаалд томилоогүйтэй холбогдох шүүхийн шийдвэрээр 3.5 сая төгрөгийн хохирлыг байгууллагын төсвөөс барагдуулсан боловч гэмт буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

6.3.3 ПРОГРАММ ХАНГАМЖИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ СУДАЛГАА

Санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн ТЕЗ-ын харьяа байгууллагуудаас ирүүлсэн судалгаанаас нийт 42 шалгагдагч байгууллага хамрагдсан.

Аймгийн Засаг даргын харьяа 42 байгууллагын дансанд 101 программ бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр программыг байгууллагын нягтлан бодогч, нярав, бичиг хэрэг, санхүү албаны дарга, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд санхүүгийн (Acolous, Си ти Эс, Leader), ХШҮ-ний мэдээллийн цахим сангийн, хурлын менежментийн, төрийн сангийн бүртгэлийн, архивын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Мөн төсвийн байгууллагууд Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн Си Ти ЭС программыг 2022 оноос эхлэн ашиглаж байна. Харин Сүхбаатар аймгийн Асгат сумын засаг даргын тамгын газар, Сүхбаатар аймгийн Ахмадын хороо ашиглагдахгүй байгаа санхүүгийн программ /Acolous/-ыг данс бүртгэлээс хасаагүй байна.

6.3.4 СУРГАЛТ, СЕМИНАР, ХУРАЛ, ЗӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН СУДАЛГАА

Сүхбаатар аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын алба Монголын Үндэсний дотоод аудиторуудын холбооны сургалт, Удирдлагын академи сургалт, Хөвсгөл аймагт удирдах албаны зөвлөгөөн, сургалт, Дотоод аудитын сургалтуудад нийт 30.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар сургалт семинар зохион байгуулахад 20.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

6.3.5 ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ, ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА

Тайлант онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЗДТГ, ИТХ, Сүхбаатар аймгийн ЗДТГ, ИТХ, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ИТХ 7 хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй 118.0 сая төгрөгийн гэрээ хийсэн байна.

Хүснэгт №15 хэвлэл мэдээллийн байгууллагатай хийсэн ажил гүйцэтгэх гэрээ

Шалгагдагч байгууллагын нэр	Нэр	Гэрээний дүн /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Эдийн засгийн ангилал
Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЗДТГ	Саунд ов фильм ХХК	5.0	2.0	210801
Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ИТХ	Датуком	5.0	5.0	210801
Сүхбаатар аймгийн ЗДТГ	Сүхбаатарын өнгө сонин ХМБ	10.0	-	210901
Сүхбаатар аймгийн ЗДТГ	Саунд ов фильм ХХК	10.0	-	210901
Сүхбаатар аймгийн ЗДТГ	Датуком ХХК	30.0	15.0	210901
Сүхбаатар аймгийн ЗДТГ	Даам медиа ХХК	16.0	-	210901
Сүхбаатар аймгийн ЗДТГ	Улаанбаатар телевиз ХХК	6.0	-	210901
Сүхбаатар аймгийн ИТХ	Датуком ХХК	8.0	3.0	210801
Сүхбаатар аймгийн ИТХ	Улаанбаатар телевиз ХХК	6.0	3.0	210801
Сүхбаатар аймгийн ИТХ	Сүхбаатарын өнгө сонин	3.0	1.5	210801
Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ИТХ	Датуком ХХК	8.0	3.0	210801
Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ИТХ	Сүхбаатарын өнгө сонин	3.0	1.5	210801
Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ИТХ	Цахим чуулбар ХХК	2.0	-	210801
Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ИТХ	Улаанбаатар телевиз ХХК	6.0	3.0	210801
		118.0	37.0	

Сүхбаатар аймгийн ЗДТГ хэвлэл, мэдээллийн 5 байгууллагатай хамтран ажиллах 72.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 15.0 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын ИТХ хэвлэл, мэдээллийн 4 байгууллагатай хамтран ажиллах 19.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 7.5 сая төгрөг, Сүхбаатар аймгийн ИТХ хэвлэл, мэдээллийн 3 байгууллагатай хамтран ажиллах 17.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 7.5 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЗДТГ хэвлэл, мэдээллийн 1 байгууллагатай хамтран ажиллах 5.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 2.0 сая, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ИТХ хэвлэл, мэдээллийн 1 байгууллагатай хамтран ажиллах 5.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 5.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийт хэвлэл мэдээллийн байгууллагуудад төлсөн нийт 37.0 сая төгрөгийн 59 хувь буюу 22.0 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж /210801/, 41 хувь буюу 15.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал/210901/-аас зарцуулсан байна.

6.3.6 ГАДААД ТОМИЛОЛТ, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН СУДАЛГАА

Тайлант онд хамтран ажиллах гэрээ байгуулах ажлаар БНХАУ-д албан томилолтоор ажилласан Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЗДТГ-аас 1 албан тушаалтанд 6.8 сая төгрөгийн албан томилолтын нөхөн олговор олгосон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийг бодит нөхцөл, судалгаа шинжилгээ, татварын баазын мэдээлэл, зөвшөөрөл олголт, ногдуулалт, гэрээ, зах зээлийн нөхцөлтэй бүрэн уялдуулж чадаагүйгээс орлогын гүйцэтгэлд нийт 4,358.2 сая төгрөгийн тасалдал үүсэж, орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдсан байна.

2. Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг болон ОНХС-ийн шилжүүлэг буурсан нөхцөлд ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тайлант хугацааны дундуур удаа дараа өөрчлөлт оруулж, нийт 376 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 56.7 хувьтай гарсан нь хөрөнгө оруулалтын үр ашиг, дэд бүтэц, үйлчилгээний хүртээмж, иргэдийн оролцоонд суурилсан төсвийн зарцуулалтын үр нөлөөг бууруулжээ.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэр бүхий ОНӨҮГ-ын санхүүгийн дэмжлэг, баяр наадмын зардал, хөдөлмөрийн маргаантай холбоотой нөхөн олговор зэрэг зарим зардлууд эрх зүйн зохицуулалтын нийцэл, дотоод хяналтын үр нөлөө, баримтжуулалтын шаардлага хангалтгүй нөхцөлд зардлаар хүлээн зөвшөөрөгдөн туссан нь төсвийн сахилга бат, төлөвлөлтийн бодит байдал, хариуцлагын тогтолцоонд эрсдэл үүсгэж байна.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оны аудитаас хойш арилаагүй, тайлант хугацаанд нийт 65 мэдээлэл цахим системд байршуулагдаагүй нь төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдал, олон нийтийн хяналт, дотоод хяналтын чанар хангалтгүй байгааг харуулж байна.

5. Орон нутгийн 2025 оны төсвийн гүйцэтгэл тайлагналын хэлбэрээр хуульд заасан шаардлагыг ханган бэлтгэгдсэн боловч орлогын төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэрэгжилт, дотоод хяналт, ил тод байдал, эрх зүйн зохицуулалтын нэг мөр байдал хангалтгүй байгаагаас төсвийн үр ашиг, тогтвортой байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс:

1. Төсвийн орлогын төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэлд шууд суурилуулах бус, татварын баазын мэдээлэл, зөвшөөрөл, ногдуулалт, гэрээ, зах зээлийн нөхцөл, эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан шинэчилж, газрын дуудлага худалдаа, ан амьтны нөөц ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж, гэрээт болон ногдол ашгийн орлогын төлөвлөлт, хяналтыг нэг мөр болгох.

АЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга-д

1. Сумын төвийн авто зам дагуух явган зам (Халзан сум) төсөл арга хэмжээний зураг төсөв дэх зарим ажлын тоо хэмжээ нь 1.5 км авто замын ажилтай давхардал үүссэн асуудлыг нягтлан үзэх, мөн тухайн ажлын гүйцэтгэлд геодезийн хэмжилт хийлгэж, ил далд ажлын актад үндэслэн захиалагчийн зүгээс гүйцэтгэлд дахин хяналт хэрэгжүүлэх

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ САНАЛ:

1. Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу аймгийн баяр наадмын зардлыг 10.0 сая төгрөгөөр тогтоосон боловч одоогийн нөхцөл байдал, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс шалтгаалан тухайн санхүүжилт нь баяр наадмын зардлыг бүрэн хангаж чадахгүй байгаа учир уг тогтоолыг шинэчлэх шаардлага үүссэн байна.

2. Төрийн захиргааны албан хаагч буюу Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бүртгэлийн мэргэжилтэн нарт мэргэшлийн зэргийн нэмэгдлийг *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно”*, Төрийн албаны зөвлөлөөс хянаж баталгаажуулсан ажлын байрны тодорхойлолтоор тус албан тушаалд мэргэшсэн нягтлан бодогч байх гэсэн шаардлагын дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдэл олгож байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 “*захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс*”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-т “*Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр*

төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай.”, заалтуудтай нийцэхгүй байна. Мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдлийн санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, мэргэжилтэн нар авч болох хууль хоорондын уялдааг нарийвчлан зохицуулах шаардлага үүсээд байна.

3. Түвшинширээ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргыг ажлаас үндэслэлгүй халсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд ажилгүй байсан хугацааны цалин хөлс төсвөөс олгосон. Сумын ИТХ-ын даргыг огцруулах санал хураалтыг хуралдааны дэгийн дагуу нууцаар явуулснаас болж буруу шийдвэр гаргасан этгээдийг тогтоох нөхцөлд хүндрэл үүсээд байна. Ийм нөхцөл үүсэхэд буруу шийдвэр гаргасан албан тушаалтныг тодорхойлох хуулийн нарийвчлан зохицуулах шаардлага үүсээд байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 д у г а р сарын 02 -ны дотор багтаан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

---oOo---

6.4 Холбогдох байгууллагын санал:

 МОНГОЛ УЛС СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Нутгийн удирдлагын ордон, 7 дугаар баг, Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075 Утас: (976) 70518585 Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn Цахим хуудас: www.sukhbaatar.gov.mn	СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ
2026.04.20 № 01/530	
танай _____-ны № _____-т	
Тайлбар хүргүүлэх тухай	
<p>Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай танилцлаа.</p> <p>Тайланд тусгагдсан аудитын илрүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллана.</p> <p>Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн ихэнх нь байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлага, сахилга сул, мэдлэг чадвар дутмаг байгаагаас шалтгаалсан асуудлууд байна гэж үзэж байна.</p> <p>2026 онд санхүүгийн ажилтнууд мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд анхаарч 4 томоохон сургалтыг төлөвлөөд байгаа бөгөөд санхүүгийн сахилга, хариуцлагыг өдөр тутмын үйл ажиллагаандаа сайжруулан ажиллах болно.</p>	
 М.ИДЭРБАТ	

6.5 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

Шалгагдагч байгууллага тайлангийн төсөлтэй танилцаж, саналын зөрүүтэй санал ирүүлээгүй тул тайлбар гаргаагүй болно.

6.7 Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/75

Баруун-Урт сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Золзаяа)-т үүрэг болгосугай.

3.Аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоног, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Г.Мөнхзаяа), Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга (Т.Цэрэгбаяр) нарт хариуцуулсугай.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Ө.Золзаяа), аудитор (Б.Мөнхбамбар), аудитор (О.Барчидгүнсэн) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\1. А тушаал-3 2025 хянуулах.docx

2226010155